



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/96/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn
Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Амарсанаа
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn
Аудитор: Ж.Мөнхтуул
Утас: 261628 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/701
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс нийт 1,054,301.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах, сонгуулийн бэлтгэл ажлыг гүйцэтгэх ажлаар албан хаагчид гадаад улс дахь элчин сайдын яамдад гадаад албан томилолтоор ажилласан байна.

Аудитын гол асуудал

"Компанийн төрийн мэдлийн ногдол хувьд тооцон хөрөнгө шилжүүлэх тухай" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 234 дүгээр тогтоолыг үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй 16,115,170.0 мянган төгрөгийн үнэ бүхий 43 нэр төрлийн үндсэн хөрөнгийг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн төрийн мэдлийн 51 хувьд тооцон шилжүүлсэн байна.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ У.БОЛДХҮҮ
ТАНАА

Бусад асуудлын хэсэг

ХЗДХС-ын 2024 оны А/07 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу үнэт цаасыг худалдан авсан боловч тайлант оны эцэст дахин шууд гэрээ байгуулан худалдан авалт хийж, дээрх төлөвлөгөөнд нэмэлт оруулан тодотгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага



Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансн ы код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,966,730,791.60	9,123,146,789.04
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	510,547,793.70	284,583,058.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,749,646.70	134,000.00
31140	Арилжааны банк	3,749,646.70	134,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	506,798,147.00	284,449,058.00
3121	Төгрөг	506,798,147.00	284,449,058.00
31211	Төрийн сангийн харилцах	506,798,147.00	284,449,058.00
31213	Арилжааны банкин дахь харилцах	3,749,646.70	134,000.00
33	АВЛАГА	-	1,062,679,122.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	1,062,679,122.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,877,183,316.90	7,775,884,609.04
351	Түүхий эд материал	5,721,393,725.98	4,122,841,793.30
35110	Тусгай зориулалттай материал	5,721,393,725.98	4,122,841,793.30
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,920,761,069.26	1,904,030,505.08
354	Хангамжийн материал	1,203,818,521.66	1,714,902,310.66
35410	Бичиг хэргийн материал	61,052,907.66	67,529,760.66
35420	Аж ахуйн материал	1,132,080,854.00	1,185,124,050.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,684,760.00	451,672,500.00
35440	Түлш шатах тослох материал	3,000,000.00	10,576,000.00
35600	Мал, амьтад	31,210,000.00	34,110,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	7,578,999,681.00	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	7,578,999,681.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	59,749,181,782.53	42,221,611,558.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	59,749,181,782.53	42,221,611,558.51
392	Биет хөрөнгө	44,669,025,155.60	36,947,947,086.25
39201	Барилга, байгууламж	16,939,619,029.16	16,939,619,029.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,184,212,924.92)	(1,707,583,651.68)
39203	Авто тээврийн хэрэгсэл	864,228,333.37	864,228,333.37
39204	Хуримтлагдсан элэгдэл	(227,815,138.68)	(322,308,680.28)
39205	Машин, тоног төхөөрөмж	37,270,717,935.62	31,681,654,083.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,052,375,376.92)	(11,395,472,372.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,400,264,176.31	1,379,017,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(341,400,878.34)	(491,207,555.25)
393	Биет бус хөрөнгө	15,080,156,626.93	5,273,664,472.26
39301	Программ хангамж	19,983,463,414.43	10,536,821,644.27
39302	Хасагдуулга	(4,992,459,347.50)	(5,349,943,220.25)
39304	Хасагдуулга	89,152,560.00	86,786,048.24
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН	76,715,912,574.13	51,344,758,347.55
4	НИИТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,158,598,801.32	189,758,858.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,158,598,801.32	189,758,858.00
413	Өглөг	2,753,069,807.62	6,080,000.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	150,000.00	40,000.00
4136	Бусад өглөг	2,752,919,807.62	6,040,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,752,919,807.62	5,940,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	100,000.00
414	Урьдчилж орсон орлого	405,528,993.70	183,678,858.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3,599,646.70	94,000.00
41430	Барьцаа дэнчингийн урьдчилж орсон орлого	401,929,347.00	183,584,858.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	73,557,313,772.81	51,154,999,489.55
51	Засгийн газрын хувь оролцоо	73,557,313,772.81	51,154,999,489.55
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	11,560,385,034.22	11,560,385,034.22
51101	Өмч: -Төрийн өмч	11,560,385,034.22	11,560,385,034.22
512	Хуримтлагдсан үр дүн	61,950,732,776.03	39,548,418,492.77
51210	Өмнөх үеийн үр дүн	16,569,995,762.76	16,569,995,762.76
51220	Тайлант үеийн үр дүн	45,380,737,013.27	22,978,422,730.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	46,195,962.56	46,195,962.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	76,715,912,574.13	51,344,758,347.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	30,932,348,844.26	66,312,348,237.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,047,359,238.26	18,095,580,013.82
120	Нийтлэг татварын бус орлого	20,047,359,238.26	18,095,580,013.82
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	20,047,333,538.26	16,506,296,139.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,620,271,886.26	15,885,433,891.07
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,180,000.00	15,090,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,425,881,652.00	605,772,248.00
120009	Бусад орлого	25,700.00	1,589,283,874.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,884,989,606.00	48,216,768,224.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,699,508,406.00	47,162,466,744.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,088,678,694.00	43,490,769,594.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,610,829,712.00	3,671,697,150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	185,481,200.00	1,054,301,480.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон санхүүжилт	185,481,200.00	1,054,301,480.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	34,043,506,656.26	88,385,486,664.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,970,300,015.45	70,783,196,761.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,918,375,021.45	64,510,715,919.98
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,298,859,301.40	5,025,646,331.09
210101	Цалин	15,097,327.68	14,045,480.19
210102	Нэмэгдэл цалин	2,034,062,473.72	4,975,776,787.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	249,699,500.00	34,877,800.00
210105	Гэрээтийн цалин	-	946,263.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	295,125,630.77	628,531,556.69
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	202,767,367.20	429,092,358.85
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	23,854,981.38	53,661,188.53
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	18,340,387.55	24,689,584.50
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	4,560,262.85	24,694,984.36
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	45,602,631.79	96,393,440.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	159,639,170.69	280,696,962.99
210301	Гэрэл цахилгааны зардал	121,639,282.32	211,497,000.00
210302	Түлш, халаалтын зардал	28,844,831.57	56,000,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	9,155,056.80	13,199,962.99
2104	Хангамж, бараа материалын зардал	1,084,546,699.80	679,290,421.07
210401	Бичиг хэргийн материал	107,863,184.00	105,912,932.00
210402	Тээвэр, шатахууны зардал	18,890,000.00	28,698,300.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	36,493,433.25	39,480,926.89
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	5,999,500.00	15,667,700.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	58,675,760.67	386,370,562.18
210408	Бараа материал акталсны зардал	856,624,821.88	103,160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,375,000.00	65,603,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	1,449,200.00
210604	Урсгал засвар	6,375,000.00	64,154,100.00
2107	Томилолт, зочны зардал	16,988,000.00	76,017,200.00
210702	Дотоод томилолтын зардал	16,988,000.00	76,017,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	21,290,113,222.33	8,295,257,260.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,249,756,286.22	7,967,254,665.85
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	35,033,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	648,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	264,000.00	423,222.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	17,870,600.00	214,849,890.00
210807	Газрын төлбөр	138,300.00	4,200,000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	25,700.00	28,300.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	22,058,336.11	72,818,783.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,766,727,996.46	49,459,672,887.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,314,340,783.14	35,282,791,287.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	647,100.00	41,068,630.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,451,740,113.32	14,135,812,970.29

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,924,994.00	6,272,480,841.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,924,994.00	401,804,569.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,162,994.00	46,741,869.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	21,762,000.00	355,062,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,304,241,583.45
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	5,304,241,583.45
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	-	566,434,689.24
261090	Төвлөрүүлэн шилжүүлэг	-	566,434,689.24
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,073,206,640.81	17,602,289,903.22
2200	Дотоод эх үүсвэрээр	1,073,206,640.81	17,602,289,903.22
220001	Барилга байгууламж	-	7,578,999,681.00
225010	Орон нутагт шилжүүлсэн ҮХ-ийн зардал	507,070,915.01	8,749,890,828.22
225011	Орон нутагт шилжүүлсэн БМ -ын зардал	566,135,725.80	1,273,399,394.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(3,111,157,812.00)	(22,073,138,427.07)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	14,012,941.62	329,175,856.19
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	14,012,941.62	329,175,856.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(14,012,941.62)	(329,175,856.19)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(3,125,170,753.62)	(22,402,314,283.26)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	36,715,251,085.57	88,134,280,486.71
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,072,676,300.00	3,328,607,500.00
118	Бусад татвар төлбөр хураамж	2,072,676,300.00	3,328,607,500.00
1180	Бусад нийтлэг татвар төлбөр хураамж	2,072,676,300.00	3,328,607,500.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,072,676,300.00	3,328,607,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,757,585,179.57	36,588,904,762.71
120	Нийтлэг татварын бус орлого	23,742,559,479.57	34,804,415,816.46
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,742,559,479.57	34,804,415,816.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,741,908,479.57	34,800,915,816.46
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	651,000.00	3,500,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	15,025,700.00	1,784,488,946.25
123002	Илүүдэл орлоготой ЗГ-ын байгууллагаас авах шилжүүлэг	15,025,700.00	1,784,488,946.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,884,989,606.00	48,216,768,224.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,699,508,406.00	47,162,466,744.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,088,678,694.00	43,490,769,594.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,610,829,712.00	3,671,697,150.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	185,481,200.00	1,054,301,480.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчаас	185,481,200.00	1,054,301,480.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	30,257,313,668.76	83,307,893,408.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,257,313,668.76	83,307,893,408.41
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,000,047,528.15	53,725,100,519.33
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,256,359,301.11	5,026,299,445.78
210101	Үндсэн цалин	1,398,541,579.58	3,223,577,700.00
210102	Нэмэгдэл	607,688,573.45	1,074,165,931.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	250,129,148.08	418,915,914.10
210104	Үр дүнгийн урамшуулал	-	223,074,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	86,565,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	319,886,900.00	627,766,000.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	214,764,500.00	383,609,600.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	26,280,600.00	61,025,400.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	21,024,600.00	30,513,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5,256,000.00	30,513,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	52,561,200.00	122,104,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	159,444,982.63	280,696,962.99
210301	Гэрэл цахилгааны зардал	121,639,282.32	211,497,000.00
210302	Түлш, халаалтын зардал	29,666,059.07	56,000,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	8,139,641.24	13,199,962.99
2104	Хангамж, бараа материалын зардал	139,171,333.25	273,784,276.89
210401	Бичиг хэрэг	48,279,000.00	103,927,300.00
210402	Тээвэр, шатахуун	14,500,000.00	40,833,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,269,433.25	40,907,676.89

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,999,500.00	15,750,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,123,400.00	72,365,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,375,000.00	73,289,300.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	2,852,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	2,484,200.00
210604	Урсгал засвар	6,375,000.00	67,952,700.00
2107	Томилолт, зочны зардал	16,988,000.00	76,017,200.00
210702	Дотоод албан томилолт	16,988,000.00	76,017,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,202,138,711.16	18,907,651,710.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	17,744,598,868.28	16,557,733,651.17
210803	Даатгалын үйлчилгээ	-	35,033,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	648,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	264,000.00	423,222.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,019,400.00	675,819,790.00
210807	Газрын төлбөр	138,300.00	4,200,000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	46,525,900.00	401,957,647.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	380,592,242.88	1,231,835,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,899,683,300.00	28,459,595,623.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,898,828,200.00	28,420,787,393.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	855,100.00	38,808,230.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,257,266,140.61	29,582,792,889.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,924,994.00	401,804,569.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,162,994.00	46,741,869.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	36,762,000.00	355,062,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,118,944,846.61	24,223,157,008.84
213302	Засгийн газрын, ЗДНХөрөнгө	5,118,944,846.61	24,223,157,008.84
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,071,396,300.00	3,328,717,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,071,396,300.00	3,328,717,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,629,113,811.24
261090	Төвлөрүүлэн шилжүүлэг	-	1,629,113,811.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,457,937,416.81	4,826,387,078.30
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,606,120,779.00	5,052,351,814.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,606,120,779.00	5,052,351,814.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,606,120,779.00	5,052,351,814.00
220001	Барилга байгууламж	3,594,022,579.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,098,200.00	5,052,351,814.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,606,120,779.00)	(5,052,351,814.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,851,816,637.81	(225,964,735.70)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,248,610.00	510,547,793.70
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,903,440,600.11	284,583,058.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,471,232,474.22	-	437,614,226.33	11,908,846,700.55
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,471,232,474.22	-	437,614,226.33	11,908,846,700.55
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	89,152,560.00	-	(992,369,622.02)	(903,217,062.02)
D01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,560,385,034.22	46,195,962.56	61,950,732,776.03	73,557,313,772.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,560,385,034.22	46,195,962.56	61,950,732,776.03	73,557,313,772.81
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(22,402,314,283.26)	(22,402,314,283.26)
D09	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,560,385,034.22	46,195,962.56	39,548,418,492.77	51,154,999,489.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,490,769,594.00	43,483,498,457.51	7,271,136.49	100.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	43,490,769,594.00	43,483,498,457.51	7,271,136.49	100.0
210	Бараа, үйлчилгээний зардал	43,158,073,500.00	43,156,983,888.51	1,089,611.49	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,026,299,600.00	5,026,299,445.78	154.22	100.0
210101	Үндсэн цалин	3,223,577,700.00	3,223,577,700.00	-	100.0
210102	Нэмэгдэл	1,074,166,000.00	1,074,165,931.68	68.32	100.0
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	418,916,000.00	418,915,914.10	85.90	100.0
210104	Урамшуулал	223,074,900.00	223,074,900.00	-	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	86,565,000.00	86,565,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	627,766,000.00	627,766,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	383,609,600.00	383,609,600.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	61,025,400.00	61,025,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	30,513,500.00	30,513,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	30,513,500.00	30,513,500.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	122,104,000.00	122,104,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	280,697,000.00	280,696,962.99	37.01	100.0
210301	Гэрэл цахилгаан	211,497,000.00	211,497,000.00	-	100.0
210302	Түлш, халаалт	56,000,300.00	56,000,000.00	300.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	13,199,700.00	13,199,962.99	(262.99)	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	273,950,200.00	273,950,176.89	23.11	100.0
210401	Бичиг хэрэг	104,093,200.00	104,093,200.00	-	100.0
210402	Тээвэр (шатахуун)	40,833,500.00	40,833,500.00	-	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	40,907,700.00	40,907,676.89	23.11	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,750,500.00	15,750,500.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	72,365,300.00	72,365,300.00	-	100.0
2106	Эд хогшил худалдан авах	83,110,100.00	83,109,800.00	300.00	100.0

210601	Багаж, техник, хэрэгсэл	12,672,900.00	12,672,900.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,484,200.00	2,484,200.00	-	100.0
210604	Урсгал засвар	67,953,000.00	67,952,700.00	300.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	76,017,200.00	76,017,200.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	76,017,200.00	76,017,200.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	8,465,569,700.00	8,464,561,772.85	1,007,927.15	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,104,842,500.00	6,104,201,696.85	640,803.15	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	35,033,800.00	35,033,800.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	648,600.00	648,600.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	423,700.00	423,222.00	478.00	99.9
210806	Мэдээллийн технологийн зардал	1,088,219,900.00	1,088,219,454.00	446.00	100.0
210807	Газрын төлбөр	4,200,000.00	4,200,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,232,201,200.00	1,231,835,000.00	366,200.00	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	28,324,663,700.00	28,324,582,530.00	81,170.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,285,774,300.00	28,285,774,300.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,889,400.00	38,808,230.00	81,170.00	99.8
21	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	332,696,094.00	326,514,569.00	6,181,525.00	98.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	332,696,094.00	326,514,569.00	6,181,525.00	98.1
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,923,394.00	46,741,869.00	6,181,525.00	88.3
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	279,772,700.00	279,772,700.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,671,697,150.00	3,678,968,286.49	(7,271,136.49)	100.2
2200	Дотоод эх үүсвэрээр	3,671,697,150.00	3,671,697,150.00	-	100.0
222001	Тоног төхөөрөмж	3,671,697,150.00	3,671,697,150.00	-	100.0
2260	Гадаад эх үүсвэрээр	-	7,271,136.49	(7,271,136.49)	-
261090	Төвлөрүүлэн шилжүүлэг	-	7,271,136.49	(7,271,136.49)	-

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,490,769,594.00	43,490,769,594.00	-	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,490,769,594.00	43,490,769,594.00	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	43,490,769,594.00	43,490,769,594.00	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	510,547,793.70	(510,547,793.70)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	284,583,058.00	(284,583,058.00)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	146	146	-	100.0
620001	Удирдах ажилтан	15	15	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	84	84	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	47	47	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,572,271,654.75	2,572,271,654.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,517,970,174.75	1,517,970,174.80
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчаас олгосон	-	1,054,301,480.0	1,054,301,480.00
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,572,271,654.75	2,572,271,654.80
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	1,054,301,480.00	1,054,301,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	954,301,480.00	954,301,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	954,301,480.00	954,301,480.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	-	100,000,000.00	100,000,000.00
210806	Мэдээлэл технологийн зардал	-	100,000,000.00	100,000,000.00



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 148/А0170083

Улаанбаатар хот

СНАГ-2025/096/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг Засгийн газрын тогтоолоор баталсан дүнгээс илүү тогтоож, нэмэгдсэн дүнгээр 13,123,210.00 /Арван гурван сая нэг зуун хорин гурван мянга хоёр зуун арван/ төгрөгийн цалингийн зөрүүг бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т "Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын төрөлд хамаарах албан тушаалын жагсаалтыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын цалингийн доод хэмжээг мөрдөх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг Засгийн газрын тогтоолоор баталсан дүнгээс илүү тогтоож, нэмэгдсэн дүнгээр цалингийн зөрүүг бодож олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (У.Болдхүү), Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Ээлүн-Үжин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН
Ж.МӨНХТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264200

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAГ-17.Docx

1505000219



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 208/А0140083

Улаанбаатар хот

СНАГ/2025/096/НА-ТШС-СТА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

- Гадаад паспортыг хэвлэх болон бэлдэц бэлтгэх үед үүссэн алдаа, үнэт цаасны дутагдлыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК, УБЕГ хэн нь хариуцах, хэрхэн нөхөн төлөх талаар албан ёсны шийдвэр гаргаагүй;
- Үнэт цаас болон гэрчилгээг худалдан авахдаа илүү, дутуу хэвлэхгүй байх, үлдэгдэл гарсан тохиолдолд захиалагчийн хяналтад устгах талаар гэрээнд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолын 2.2.2-т "Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэл ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр, нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Үнэт цаас хэвлэлтийн алдаа, дутагдлыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК, УБЕГ-ын хэн нь хариуцах талаар шийдвэр гаргаагүй, үнэт цаас болон гэрчилгээг худалдан авахдаа илүү, дутуу хэвлэхгүй байх, үлдэгдлийг захиалагчийн хяналтад устгах талаар гэрээнд тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (У.Болдхүү), Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Өэлүн-Үжин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДОЛГОРСҮРЭН
АХЛАХ АУДИТОР П.АМАРСАНАА
АУДИТОР Н.НЯМСҮРЭН
Ж.МӨНХТҮҮЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-17.Docx

1525900407



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 207/А0140083

Улаанбаатар хот

СНАГ-2025/096/НА/СТА-ТШС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Гадаад харилцааны яамтай үнэт цаас болон сонгуулийн санал хураахад ашигладаг хурууны хээ уншдаг тоног төхөөрөмж, иргэний мэдээллийн сан агуулсан компьютерыг баланст бүртгэсэн эсэх ашиглалтад хяналт тавьдаг талаар жилийн эцэст зарцуулалт болон үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Гадаад харилцааны яамтай үнэт цаас, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (У.Болдхүү), Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Өэлүн-Үжин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДОЛГОРСҮРЭН
АХЛАХ АУДИТОР П.АМАРСАНАА
АУДИТОР Н.НЯМСҮРЭН
Ж.МӨНХТҮҮЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-17.Docx

1525900407



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

206/А0140083

Улаанбаатар хот

СНАГ-2025/096/НА/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, нэмэлт гэрээ байгуулахгүйгээр гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн 21,170,000.00 /Хорин нэгэн сая нэг зуун далан мянган/ төгрөгийн шатахуун худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, нэмэлт гэрээ байгуулахгүйгээр гэрээний үнийн дүнг хэтрүүлэн бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (У.Болдхүү), Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Өэлүн-Үжин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН
Ж.МӨНХТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-17.Docx

1525900401



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

205/А0140083

Улаанбаатар хот

СНАГ-2025/096/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үндэсний дата төвөөс балансаас баланст шилжүүлэн авсан 11,868,000.00 /Арван нэгэн сая найман зуун жаран найман мянган/ төгрөгийн үнэ бүхий 138000 ширхэг ашиглалтаас гарсан ТҮЦ машины лавлагааны маягт бүртгэлгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11-д "төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Нийлүүлэгч байгууллагаас хүлээн авсан бараа бүтээгдэхүүний чанарын шаардлагыг хангуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (У.Болдхүү), Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Өэлүн-Үжин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН
Ж.МӨНХТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-17.Docx

1525900399